

**ЮННАНЫ МОНГОЛЧУУДЫН ЧИНГИС ХААНЫ
ТАЙЛГА ТАХИЛГА**

С.Дулам¹

2009 оны 7 дугаар сарын 26-наас 31-нд БНХАУ-ын Юннан мужийн төв Күнмин хотод болсон Дэлхийн хүн судлаачид, угсаатан судлаачдын 16-р их хуралд оролцохын ялдараа тус Күнмин хотоос урагш 100 орчим км зайд орших Дунхай хошууны Шинмэншиан (Xingmeng xiang) (“Шинэ Монгол”) суманд байх монголчуудтай уулзаж, Чингис хаан, Мөнх хаан, Хубилай хааны тахилгын сүмийг үзэж саатах завшаан олдсон юм. Америкийн эрдэмтэн Хенри Шварцын судалснаар бол орон нутгийн засаг захиргааны данс эвхмэлээс үзэхэд харьцангуй цөөн тооны монголчууд Жиндон, Мэнзи, Хунмин, Жэху зэрэг гучин есөн хошуунд тархан суудаг бөгөөд олонхи нь “Шинэ Монгол” (Xingmeng xiang) сумын таван тосгонд байдаг байна.² Бидний очсон газрын нэр бол “Монгол үндэстний нутгийн Дунхай сианы Монголоо мандуулах ардын засгийн ордон, Ардын төлөөлөгчдийн их хурал” гэсэн хаягтай бөгөөд “Шинэ Монгол” (Xingmeng xiang) сумын дарга Гуань Шуэ-цин (Guan Xue-qing) биднийг газарчилж танилцуулсан болно. “Шинэ Монгол” сум нь биднийг очих үесээр 11 монгол овогтой, овгийн тоолонгоор Мин улсын үеэс тахиж ирсэн өвгөдийн онгонтой, нийт 13000 хүн амтай³ хэмээн мэдээлэв. Жил бүрийн хавар намарт хоёр удаа эл 11 овгийнхон бүгдээрээ өвөг дээдсээ тайж тахидаг уламжлалтай ажээ. “Шинэ Монгол” сум нь Дунхайн тал нутгийн баруун хязгаарт орших бөгөөд Фэн-хуан шан буюу Гарьд уулын бэлд, Хи-лу буюу Рашаант нуурын хөвөөнд оршдог аж. Тэр нь үлгэр домгийн Алтан Гарьд Рашаант нуурын усыг умдаалан алсыг зорин дүүлэх гэж байгаа шиг харагддаг аж.

Юннаны монгол үндэстний уламжлал ярианаас үзвэл монголчууд Фэн-хуан шан буюу Гарьд уулын бэлд эхлэн суух үед Фэн-хуан шан уул үнэхээр нэг амьд Алтан Гарьд байж, Хэ Си сианы хот бол даруй Гарьдын үүр байсан юм гэнэ. Ажилч хөдөлмөрч бөгөөд сайн санаат Алтан Гарьд өдөр болгон үзэсгэлэн сайхан хээр хөдөө идээшилж, орой болбол үүртээ буцаж ирээд зулзагануудаа энхрийлэн тэжээж, амар мэнд аз жаргалтай амьдарч байв гэнэ. Сүүлээр нь нэгэн салаа ноёны цэргийн эрхтэн хийгээд харгис газрын эзний цэрэг Фэн-хуан шан уулын хавьд ирээд Хэ Си сианы хотыг эзэлж, ножидлон бузарлах, галдан дээрэмдэх мэтээр харгислан самуурч, Алтан Гарьдын зөөлөн дулаан үүрийг талхилж, үр зулзагыг нь хөөн явуулав. Хөөрхий Алтан Гарьд зулзагаа дагуулан эзгүй хөдөө хонож хэвтэн, өл хоолгүй тэнэж явлаа гэнэ. Алтан Гарьд зовж зүдсээр байгаад ясан годой болтол эцэж турав. Гэвч тэр мөн л эрс зоригтойгоор жигүүрээ дэлгэн гэдийж зогсоод сүрлэг сайхан Фэн-хуан шан уул болон хувирч гэнэ. Эдүгээ Фэн-хуан шан уулын алсын бараа нь мөн манан

¹ МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

² Генри Г. Шварц. Историческое происхождение юннанских монголов. С. 1

³ Проф. Х.Шварцын судалж байх үед «Шинэ Монгол» сумын хүн ам нь 4300 хүнтэй 1150 гэр бүлээс бүрдэх бөгөөд энд 33 йи үндэстэн, 23 хан үндэстэн байсан ажээ.

хүдэнгийн дундуур жигүүрээ дэлгэн дүүлж байгаа Гарьд галбингын шинжтэй байдаг. Ховдог шунахай ноёдын цэргийн эрхтэн хийгээд харгис газрын эзэд ард иргэдэд хар алба тулган уулыг дэлбэчин чулуу гаргаж хот балгас байгуулж эхлэв. Хөөрхий Алтан Гарьд мөчлөгдөн талхигдаж л байлаа. Гэнэт нэг өдөр уулын завсраас ув улаан цус урсан гарч ирээд уулыг будлаа, өвсийг будлаа, уулын энгэрээр горхилон урсч, Жүн Хэ голыг ч улайлгаж орхилоо... Алтан Гарьд ингэж талхигдан тамлагдсаар эмгэнэлтэйгээр амиа алдсан байлаа. Үүнээс хойш Хөтөл боомт ба Хэ Си сианы орчмын нуур голын ус ширгэж, өвс мод хувхайран, ус гангийн аюул ба бусад зүйлийн гай гамшиг үл тасран, Монгол, Хятад, Хотон зэрэг үндэстнүүдийн ард түмэн гал усны аюул зовлонд уналаа гэнэ.⁴

Анх 1253 онд Дали улс гэж байх цагт Мөнх хааны монгол цэрэг Юннаныг засан тохинуулжээ. Тэр цагаас хойш 1381 оныг хүртэлх 38 жилийн турш Чингис хааны угсааны монгол ноёд Юннаныг захирсан байна. Үнэн хэрэгтээ “Дайюан улсын түүхэнд” монголчууд Юннаныг эзэлсэн тухайд тоймтой зүйл эрээд олдсонгүй. Харин Юан гүрний бичгийн яамны сайд Чэн Вэн-хайн зохиосон “Юан Шизу Юннаныг төвшитгөсөн хөшөөний” бичээс, Юннан мужийн ялгагч түшмэл Ли Тайн зохиосон “Бүгдийг захирах юаньшуайн ордон Күнзийн сүм байгуулсан хөшөөний тэмдэглэл”, “Пу Гуанг шан уулын Жи Жоу хийдийн тэмдэглэл”, “Зарлигаар талбигсан дэлгэрэнгүй тохинуулах хэлтсийн Бүгдийн дарга дээд өвөг ноёнтон Алтөмөр монголын Иү Заны онгоны тэмдэглэл”, “Мин улс, Чин улсын үед нөгчигсөн Жоу овогтны холын төрөл садан эцэг эх дээдсийн онгоны бичиг”, “Ся Зүн тосгоны өнөд мөнхөртүгэй хэмээх хөшөөний тэмдэглэл”, “Хэ Си шияаны мэдэгч Жүн Юй Зүн тосгоны ар уулыг хамаарах явдлыг зарласан хөшөөний” бичээс, “Юннаны монгол үндэстний зан дадгаал”, “Юннаны монгол үндэстний уламжлал ярианы сонгомол”, Дү Юй-тингийн “Юан улсын үеийн Юннаны аймгийн түшмэлийн дүрэм” зэрэг орон нутгийн чанартай данс эвхмэл, хөшөө чулууны бичиг зэрэгт зарим нэгэн мэдээ занги голлон уламжилжээ.

Монголын язгууртан Сүн улсыг дайлахдаа хэдүйвээр үлэмж амжилт олсон боловч урт хугацааны хатуу ширүүн эсэргүүцлийн өмнө хүнд сүрхий үрэгдэл сүйдэл гаргав. Тэр үйлдэлгийн дундаас Өмнөд Сүн улсыг мөхөөх явдал тийм хялбар бус байсныг мэдээд бүслэн цохих арга бодлогыг сүвэгчилжээ. Ингээд баруун өмнөд хязгаарын Юннаныг харин энэхүү бүслэн цохих бодлогыг биелүүлэхдээ хамгийн түрүүн эзлэх хэрэгтэй чухал газар болгосон байна. Өөрөөр хэлбэл, Мөнх хаан, Хубилай хаан хоёр Юннан мужийг Сүн улсыг бүрэн эзлэх дайны түшиц газраа болгосон гэсэн үг. 1252 онд Чингис хааны жич хөвгүүн Мөнх хаан дүү Хубилайдаа арван түмэн цэрэг өгч, Юннаныг дайлуулав. 1253 онд монгол цэрэг Нинсягаас мордож, Ганьсугаар дайран Сычуанд хүрсэн бөгөөд тэндээс цэргээ гурван зам хувааж, Юннаныг цохисон байна. Баруун замын цэргийг Урианхадай жаанжин удирдаж, Чухаяжила зүүн замын цэргийг удирдаж, Хубилай дунд замын цэргийг удирджээ. Хубилай одоогийн Ян-юан, Нинг-ланг өнгөрөн Жин-ша-жянг мөрнийг “тулам салаар гэтэлж”, Далид цэрэг ороод Юннаны нутаг орныг хэсэглэн эзэлсэн Дали улсыг мөхөөжээ. 1254 онд Хубилай 1252 онд цэргээ татахдаа өрлөг жанжин Урианхадайгаа хоцроож, Юннаныг сахиулжээ. Хубилай цэрэг орохдоо монгол морьт цэргийн зохион байгуулалтын онцлогийг ашигласан болохоор гайхамшигт ялалт байгуулав. Энэ бол Хятад улсын түүхэнд ер гараагүй билээ. Цэрэг орох явцдаа Хубилай хүмүүсийн сэтгэлийг олохын төлөөнөө монгол цэргийн ямагт хэрэглэдэг “хядах” төрийн бодлогоо өөрчлөв. Дали улсын эзэн

⁴ Du Iui Ting, Čen Liui Ban. Yünnan-u mongyol ündüsüten-ü tobči teüke. Öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a, 1980, Kökeqotan-a, 160-162 [Du Iui Ting, Čen Liui Ban 1980]

хэдүйвээр Хубилайн томилсон ятган дагуулах элчийг алаад толгойг нь модонд өлгөж, цээр үзүүлсэн бөгөөд зэвсэгт хүчнээр эсэргүүцсэн боловч Хубилай хаан хотыг байлдан авсан хойноо мөнхүү “хядахыг цаазлах” зарлиг буулгав. Юан улсын бичгийн яамны сайд Чэн Вэн-хайн зохиосон “Юан Шизу Юннаныг төвшитгөсөн хөшөөний” бичээс бол энэ тухай өгүүлдэг. Урианхадай бол Юан улсын төр байгуулахаас өмнөх үеийн нэртэй жанжин мөн бөгөөд Юннаныг төвшитгөх, Юннанаас өмнөд Сүн улсыг байлдах бодлогын бүслэлт хийх ба дайран довтлох үед чухал үйлдэл үзүүлсэн [Du Iui Ting, Ĉen Liui Ban 1980, 4-7] болно. 1368 онд Жү Юан-жан Мин улсыг байгуулсан атал Юан улсын Шүнди хаан буюу Тогоонтөмөр хаан Монголын хуучин нутагтаа ялагдан буруулсан атал Юан улсын Юннанд өргөмжилсөн Лианг ван мөн бууж өгсөнгүй. Ингээд 1381 онд Мин улс байгуулагдаад 13 жил болсны дараа сая Фу Ею-дэ, Му Инг хоёрыг зарлигдан гучин түмэн цэргээр Юннаныг дайлав. Хоёр улсын цэрэг Юннаны зүүн хэсэгт ширүүн тулалдаан хийж, Юан улсын арван түм илүү цэрэг бут ниргэгдэн Лианг ван Базарварми Жиннинд дутаан хүрч биеэ хорлоод Юан улсын Юннан дахь ноёрхол сая эцэслэсэн байна [Du Iui Ting, Ĉen Liui Ban 1980, 9-10]. Хятад тэмдэглэл дэх зарим улс төрийн хэрэг явдалтай холбогдсон хэсэг бусад түүхийн материалд Юннаныг сахиж байсан Урианхадай бол Монголын “дөрвөн вангийн” шилдэг морьт цэргийг удирдаж байв. 1267 онд Хубилай Юннан дахь ноёрхлоо чангатгахын тулд тавдугаар хөвгүүн Үхэрчийг “Юннан вангаар” өргөмжилж, Юннаныг захируулав. 1290 онд Юннан вангаас бас эрх сүртэй “Лианг ван” гэж өргөмжилсөн бөгөөд Хунтайж Жингхений ууган хөвгүүн Гамала анх түрүүн Лианг вангаар өргөмжлөгдсөн юм. Урьд хожид арав гаруй хүн Лианг ван буюу Юннан вангаар өргөмжлөгдсөн боловч олонхи хүний түүх тэмдэглэл дутмаг учраас хэрэг учир нь тодорхойгүй [дээрх ном 10-11] юм.

Гэвч бид энэ удаагийн зорилго бол Юннаны монголчуудын түүхийг он дараалан өгүүлэхэд биш, харин тэдний соёл суртахуун, зан дадгаалыг сонирхон авч үзэхэд оршино. “Юннаны монгол үндэстний зан дадгаал”-д тэмдэглэснээр Юннаны монгол үндэстэн цагаан сар, ханш, таван сарын таван, найман сарын тэргэл зэрэг баярыг бэлгэлэх бөгөөд зургаан сарын хорин дөрвөний гал бамбарын баярыг ч эрхэмлэж, энэ өдөр тариандаа очин “эх газрыг” тайж, хүүхэд багачууд таван өнгийн утас зүүдэг. Залуу идэрчүүд үдшээр гал бамбар өргөн нааддаг. Эдгээр нь цөм өвчин зовлон гай гамшгийг арилгахын төлөө юм гэнэ.

Шашин шүтлэг нь туйлын будлиантай. Таван тосгонд Хоншим бодисадва, Хаан Хурмаст, Лооез бурхан, Намсрай бурхан, Күй Хэ, Лю Бан, Лусын эзэн, Уулын сахиулсан, Газрын эзэн зэрэг арав гаруй бурхан сахиулсны сүм байх юм. Гэр бүлдээ галын бурхан, “тэнгэр газар эзэн эцэг эх багш” хийгээд өвөг дээдсийн шүтээнийг тахидаг. Овог угсаатан нь тус тусдаа дээдсийн сүмтэй. Тосгондоо бас хэд хэдэн удгантай бөгөөд олонхи сүм нь цөм сүмийн тариатай, их сүм нь бас тогтсон хугацаанд хурал хурдаг бөгөөд хоёр сарын арван есний Хоншим бодисадвагийн сүмийн хурал хамгийн өв тэгш байдалтай юм. Гэрт жирэмсэн эмэгтэй хөнгөжиж байвал гэрийн гадаа үүдэнд сүлдсэн (үндэсний) малгай өлгөж, цээртэйгээ мэдэгдэх бөгөөд хүү төрвөл зүүн талд, хүүхэн төрвөл баруун талд өлгөдөг байна. Чухам энэ зүг чигийн бэлгэдэл нь манай халх, ойрадын ёсноос өөр юм байна. Хөнгөжигсдийн сард сууж байгаа үед өөр бусад хүн гэрт нь орж болохгүй. Тэдний үзэхээр өөр бусад хүн орж ирвэл “эхийн сүүг ширгээж”, хүүхэд өвчилдөг гэнэ.

Биднийг очиж уулзах үесийн Юннаны монголчуудын байр байдлыг дурдвал 1253 оноос хойшхи энэхүү 756 жилийн хугацаанд гадаад дүр байдал, бие бялдын хувьд өмнөд орны хүний дүр төрхтэй болоод хэл соёлын хувьд ч гэсэн өнөөгийн халх болон өвөрлөгч нартай аль алинтай нь ч харьцуулахад бэрх өөр болцгоожээ. Хэлний хувьд хятад хэл, монгол хэлний алинтай нь ч төсгүй “казуу” хэмээх хэлээр хэлэлцдэг бөгөөд энэ нь хятад,

монгол, йи үндэстний хэлний аль алиных нь нөлөө байх шиг байна. Тэхдээ зэрвэсхэн ажиглаж үзэхэд монгол хэлний үгсийн сангийн зарим үгс хэвээрээ болон бага зэрэг өвөрдсөн байдалтай байна. Жишээ нь, аавыг (а ра) чихийг “навч” (na po tcha), хамрыг “нагмай” (na khu mε), хамрын нүх (na khu to), хамрын үс (na khu nu) гэхчлэн хэлэхээс гадна “хамиа үгүй ээ” (ха ma khuan), “аяхав” (ха ma khu) ⁵ гэхчлэн ярьж байна. Зарим судлаачдын үзэхээр бол одоогийн тэр “казуу” (ka Zhou) хэмээх хэлний арван хувь нь л монгол хэлтэй адил төстэй юм байна. Улс тунхагласны дараа “Шинэ Монгол” сумаас Өвөр Монгол руу залуу идэр хүмүүсээ илгээж, өөрсдийн хэл, соёл, зан заншлаа сургаж байгаа бөгөөд тэнд явж суралцсан Баатар гэдэг залуу бидэнд өөрсдийн энэ ёс заншил, үүх түүхээ танилцуулсан болно.⁶

Хувцас хунарын хувьд сэрүүн орны урт дээлээ халуун газрын богино цамц өмдөөр сольсон байна. Чингэхдээ одоогоос жар далан жилийн өмнө эрэгтэйчүүд нь халх өвөрлөгчдийн адил урт хормойт дээлээ өмсдөг байсан гэсэн мэдээ байна. Күнмин хотод тааралдсан монгол хүн болохоор манай өвөрлөгчдийнхтэй адил монгол дээл хувцастай байсныг үзвэл бас урт хормойт дээлээ сэргээх гэж оролдож байгаа бололтой. Гагц бусад үндэстний цамцаас ялгаатай нь “Шинэ монгол” тосгоныхны цамц нь босоо захтайгаараа монгол цамцтай адил байна. Эхнэр хүүхэнчүүд нь монгол эхнэрийн уужны цээживч хэсэгтэй төстэй урдуураа задгай олон товч бүчтэй, хээ угалз болсон богино хүрэм маягийн хувцас өмсдөг юм байна. Хувцас хунар нь голдуу хар, хөх өнгөтэй байдаг нь уламжлалт монголчуудын эрхэмлэдэг өнгийг зардаг гэсэн үг.

Эрхэлдэг аж ахуйн хувьд гэхэд “Шинэ монгол” тосгоныхон маань голдуу загас агнуур, газар тариалан эрхэлдэг, үхэр, адуу, хонь, ямаа гэх мал үгүй харин гахай голлон малладаг байна. Чухам ийм учраас малын мах шүүсээр хооллоно гэж үгүй, будаа тариа, ногоо голлон иддэг бөгөөд биднийг очиход могой загас, хуурсан өт голлон таваглаж байлаа (Зураг). “Шинэ монгол” тосгоныхон манай монголчуудаас ялгаатай нь адууны мах идэхийг цээрлэдэг, учир нь энэ алс холын оронд хүргэж ирсэн үнэнч нөхөр хэмээн үзэх тул ийн цээрлэдэг ажгуу.

Бидний хамгийн ихээр үзэж сонирхсон юм бол Чингис хаан, Мөнх хаан, Хубилай хааны тахилгын сүм болно. Тахилгын сүмийн үүдний гаднахи хос баганын баруун талынх дээр “Гурван их өвөг дээсийн бүтээн байгуулсан Юан гүрний бадрангуй зоригийг дэлхийн түүхийн хуудсанд мөнхөлнө” гэсэн шиг утгатай, зүүн талынх дээр нь “монгол үндэстний ард түмний сэтгэл зүрхэнд шингэсэн нэр төрийг үүрд дурсан хадгална” гэсэн шиг үгсийг ханз үсгээр бичжээ. Энэ сүм нь бүр Мин улсын үед баригдаж, хятадын дайны тэнгэр Гуан Лооез Богд буюу хятадын Гэсэр хааны тахилгын сүм байснаа Манж Чин улсын Бүрэнт засагчийн (Түн-жигийн 1856-1875) арван гурван он буюу 1874 оноос Чингис хаан, Мөнх хаан, Хубилай хааны тахилгын сүм болсон байна. Тэр цагаас хойш зуу гаруй жил тасралтгүй тахилга ёслол үйлдэж байгаад “Соёлын хувьсгалын” жилүүдэд тасарч, өвөг дээдсийн онгоны олон суварга бунхан устаж алга болсны нэгэн адил сүйдэж хохирсон боловч 1978 оноос нууцаар сэргээн тахидаг болжээ. Ингээд 1985 оноос Чингис хаан, Мөнх хаан, Хубилай хааны тахилгын сүмийг эгүүлэн сэргээж, гурван хааныхаа хөшөө баримлыг бүтээж, “гурван хааны орд, гурван богдын орд” (“san sheng gong”) хэмээн өөрчлөн нэрлэдэг болж, жил бүрийн хуучин тооллын 6-р сарын 20-нд ёсолдог болжээ.

⁵ Yun nan tong hai xing meng: Meng gu zu ha zhao yu. P.

⁶ Юннан монголчуудын талаар бидэнд танилцуулсан “Шинэ Монгол” (Xingmeng xiang) сумын дарга Гуань Шүэ-цин (Guan Xue-qing), энэ нутгийн монгол Баатар, Сэцэн нарт гүнээ талархаж байна.

Юннан монголчуудын үндэсний баяр болох өвөг дээдсээ тахих баяр нь (yizujiе) ийнхүү жил бүрийн хуучин тооллын 6-р сарын 20-ны өглөө эрт хөгшин залуугүй хүн бүр хамгийн гоё сайхан хувцсаа өмсөөд гурван хааны шуумал бүхий тахилгын сүмийнхээ үүдэнд цуглараад “Шинэ Монгол” тосгодын өтгөс буурлын дотроос хуучин ёс уламжлалаа сайн мэддэг, учир мэдэх нэгэн өтгөс бүх ёслолыг удирдан дэглэж, эхлээд гурван хаандаа хадгаа өргөөд, дараа нь гурван цөгц архи сархад дээжлэн хадагтай өргөнө. Түүний дараа Чингис хаан болон өвөг дээдсээ алдаршуулан магтсан магтуу дуу дуулцгааж, цугласан олон бүгдээрээ нас намба, эрх тушаал зэргийн дагуу эзэн хаандаа ёслон мөргөнө. Мөргөхдөө ямагт умар зүг тийш хандан мөргөдөг онцлогтой юм байна. Тэндээсээ дараалуулан идээ будаа өргөж, өөрсдөө хамгийн амт шимтэй сайн сайхан зоог идээгээ зооглоно. Үдээс хойш 15 цагийн үест “Шинэ Монгол” тосгодын дарга, албан тушаалтнууд цугласан олон хүмүүст хандаж, албан ёсны үг айлтгал хэлнэ. Тэгээд өөрсдийнхөө үүх түүх, уг гарлыг Умард Монголын орны үр сад, Их эзэн Чингис хаан, Мөнх хаан, Хубилай хааны удам хойчис, албат харъяатууд гэдгээ дурдаж, энэ газар нутагт ирж, дасаж суурьших гэж хэрхэн зовж зүдэж байснаа дурсан, өөрсдийн түүх намтраа залуу хойч үеийнхэндээ ярьж өгдөг байна. Энэ баяр ёслол ийнхүү бүхэл өдөржингөө үргэлжилдэг байна. Энэ гурван Богдын тахилгын үеэр тэдний тосгодын ёс заншлаа мэддэг хориод тооны настай намбатай хүн өвөг дээдсийнхээ хөрөг баримлыг авч нэг гацаанаас нөгөө гацаанд цэнгүүлэн явдаг. Хүмүүс угтаж авахдаа арц, хүж унгасган, идээ будаа, чихэр боов барьж, хятадын их дуут цаасан буу буудуулж (bianpao), сүр жавхлантай угтан авцгаадаг байна.

Ёслолын гол утга учир нь залуу хойч үеийнхэндээ гарал үүсэл, үүх түүхээ мартуулахгүй байлгаж, өвөг дээдсийнхээ сүнс сүлдийг баясгаж, жил бүр алгасалгүй тайж тахиж явахад орших ажээ. Бас жил бүрийн 12-р сард наадам хийж, тайлга тахилга хийж, бөх барилдаж, наймаа арилжаа хийдэг байна. Ер нь “Шинэ Монгол” тосгоныхон өөр зуураа эв найр сайтай, угсал ялдам зан ааштай, найрсаг зочломтгой, гэрт зочин хүрч ирвэл цай цүү аягалж, тамхиар дайлна. Гэрт ирсэн зочиндоо бага залуу охид архи барьж дуулна. Архиа тогтоохдоо хундагатай архиа толгойноос дээш өргөөд хуруугаа дүрж, тэнгэрт нэг, газарт нэг өргөнө. Айл болгон бурхан шүтээнтэй, тэр бурхан шүтээндээ гаднын хүн хүргэдэггүй, бурханы тахилын ширээн дээр хамаа бус юм тавьдаггүй болой.

Юннаны монголчуудын хуримын ёслолын тухайд гэвэл монгол ёс заншлын ёсоор нэгэн овогтой хүмүүс өөр хоорондоо гэрлэж болдоггүй нь хатуу тогтсон зүйл болно. Юан гүрний үеэс өмнө нэг эр олон эхнэртэй байж болдог байсан бол Юан гүрний үеэс энэ ёс халагдаж, нэг эр нэг л эхнэр авдаг болжээ. Тэхдээ монгол угсаат овгийнхон өөр хоорондоо л урагладаг, эрчүүд нь өөр яс угсааны хүүхэн авч болдог бол хүүхэнчүүд өөр яс үндэсний эрчүүдтэй гэрлэхийг зөвшөөрдөггүй явж иржээ. Харин одоо энэ байдал өөрчлөгдсөн бололтой. Бидэнд гурван хааны ордон үзүүлж тайлбарласан монгол бүсгүй гэхэд хятад хүнтэй урагласнаа бахархангуй ярьж, сайхан залуугийн гэрэл зураг үзүүлж байлаа. Ураг тогтоох ёс нь хэд хэдэн үе шатыг дамждаг байна. Нэгдүгээрт, эцэг эх нь уулзан ярилцаад хүүхдүүдээ хуримлуулахаар тохирно. Хоёрдугаарт, махчилбал “найман үсэгт хүн” (bazi xiansheng) буюу найман хүлил мэдэгч хүнийг залж, ураг тогтох болсноо үзүүлж, ирээдүйн сайн сайхан аж амьдралыг нь даатган баталгаажуулна. Гуравдугаарт, сүй бэлэг хүргэх ёс үйлдэнэ, энэ нь хүүгийн гэрээс архи тамхи, чихэр боов, мөнгө төгрөг хүргэж ирнэ. Хуримын өдрийг товллохдоо үзлэг үзэж байж өлзийтэй сайн өдөр сарыг товлно. Хүү болон хүүхний эцэг эх өөр өөрсдийн гэртээ ах дүү хамаатан саднаа цуглуулж, ямар өдөр сард хурим товлосноо зарлана. Хуучин цагт хурим товлосны дараа хүүгийн тал бол хуримыг

цуцлах эрхтэй байсан бол хүүхний тал хуримыг цуцлах эрхгүй байжээ. Тэгээд яг хуримын өмнөх шөнө хүүгийн талаас хүүхний гэрт бүрэн хувцас хэрэглэл, улаан цаасанд боодолтой архи, мах, чихэр сэлтийг хүргүүлдэг байжээ. Дөрөвдүгээрт, жинхэнэ хуримын ёслол болно. Хуримын өглөө хүргэн болох залуу нь өөрийн талын идэр залуу эрсийн хамт ирж, бэр болох бүсгүйг авч явдаг байна. Чингэхдээ цагаан өнгийг төлөөлүүлсэн давс, урган төлжихийг төлөөлүүлсэн ногоон ногоо авч ирдэг. Бэрийн гэрт хоёр ширээ зассан байх агаад нэг ширээнд нь хүргэн ганцаар сууж хооллодог бол нөгөө ширээнд нь хамт ирсэн хүмүүс нь хооллодог гэнэ. Хооллох үедээ хүргэн өөрөө хоолноос авч дураар идэж болдоггүй, харин тусгайлан зарагдсан нэгэн хүн ширээн дээр байгаа хоолноос бага сагаар авч, хүргэний аяганд хийж өгдөг байна. Гол учир нь ширээн дээр байгаа идээ зоог хонхойж хотойтол дундарч байх ёсгүй, тухайлбал, загас идлээ гэхэд нэг талыг нь идсэн бол нөгөө идээгүй талаар нь буцааж тавьдаг заншилтай гэнэ. Энэ нь бидний бодлоор “дүүрэн бэлгэтэй, төвшин жаргалтай” байхын бэлгэдэл буй заа. Хүргэн залуу хадмын газраас мордохдоо тэр айлаас бага сага хоол хош, архи дарс, нэгэн хос савх авч, өөрийн өвөг дээдсийн онгодод өргөнө. Энэ үед бэрлэх бүсгүй үс гээгээ эхнэр хүний ёсоор янзлаад хадмын гэрээс ирүүлсэн хувцас өмсгөлийг өмсч, толгойгоо улаан эдээр боож, амуу будаа дүүргэсэн саван дээр гарч зогсоно. Энэ нь элбэг баян, тарган цатгалан явахын өлзий бэлгэдэл болох нь тодорхой байна. Бэрлэх бүсгүй төрсөн гэрээсээ гарч явахад эцэг эх нь хос шил архи, хос загас, хоёр хэсэг гахайн гэдэсний болсон мах өгчилгөж явуулна. Энэ бол ирээдүйн залуу хос бат бэх, эв найртай амьдрахыг бэлгэдэж байгаа нь тодорхой байна. Энд улаан өнгийг үлэмж зарах болсон нь нанхиад соёлын нөлөө хүртсэнийх бизээ. Хуримын өглөө хүргэн болох залуу хүүхнийг аваад буцах замдаа нэг ч үг дуугарах ёсгүй гэнэ. Бэрлэж буй бүсгүй төрхмөөсөө гараад хүүгийн гэр хүрэх замдаа тувт тутарга сацсаар явна. Шинэ бэр шинэ аж амьдралын замдаа орлоо гэсэн бэлгэдэл утгатай юм гэдэг. Бэр бүсгүй зам зуураа болон шинэ гэртээ очин очтолоо уйлж хайлсаар л байна гэнэ. Эцэг эхийн гэрээс гарч, эгч дүүсээсээ саллаа гэсэн утгатай юм санж. Айл болох гэрийнхээ үүдэнд хүрэхэд нь дөрвөлжин ширээн дээр өөг цатгалан байхыг бэлгэдсэн таван зүйлийн амуу будаа, шударга журамтай байхыг бэлгэдсэн жин жинлүүр, эетэй эвтэй байхыг бэлгэдсэн уртын хэмжүүр, муу юмнаас хамгаалахыг бэлгэдсэн толь, аз жаргалтай, буян хишигтэй байхыг бэлгэдсэн бичигт ариун цаас (shuang xi) сэлтийг бэлтгэсэн байна. Хадамын гэрийн үүдээр ороход бичигт ариун цаасаа шатааж, гал усны саадыг цуцална. Нэг нь галаа барьж, нөгөөх нь савтай усаар цэцгийн эрхи юмуу цэцгийн хүрээг усална. Гэрт ороход бэрийг уйлж унжихаа боль хэмээн аргадна. Тэгээд толгой боосон хар алчуурыг нь авч хурим дэглэгч эртний дуу дуулж, шүлэг ерөөл хэлж, амуу буудай сацаж, ариун цаас шатаана. Цаасны шатсан үнснээс нь архинд хийж, шинэ бэрд уулгана. Залгаагаар арваад насны бага охин бэрлэж буй бүсгүйд хоол өгнө. Бэрлэгч бүсгүй хоолноос идэхгүй. Эр нөхрийн талын эгч дүүс бэрийг шинэ өрөөнд нь оруулж, толгойг боосон улаан алчуурыг авч, гэр байшингийн голд суулгана. Оройн зоогийн үест гэрлэсэн хос залуу хадам ээж болон эгч ахайтнаараа дэмнүүлэн цугласан зочдын ширээ болгон дээр очиж, гурван хундага дарс тогтооцгооно. Зоогийн үеэр бэрийн гэрээс ирүүлсэн мах шүүсийг идэж зооглоно. Ёслол дуусаад хос хоёр шинэ өрөөндөө орно. Маргааш өглөө нь гэрлэсэн хос бэрийн төрхөмд очиж, тэнгэр, газар, бэрийн өвөг дээдсийн онгонд мөргөж ирээд, хүргэн хүүгийн гэрт бас тэнгэр, газар, хүргэний өвөг дээдсийн онгонд мөргөнө. Энэ бол тэнгэр, газар, хүргэн бэрийн өвөг дээдсийн онгоноос зөвшөөрөл авсантай утга нэгэн ажгуу. Гурав дахь өдөр нь гэрлэсэн хос нэг залуу эр, залуу эмэгтэйн хамт гахайн толгой болон идэх уух юм аваад хүргэн бэрийн эцэг өвгөдийн шарил дээр очиж, мөргөж золгоно. Тэндээс эргэж ирээд бэр нь галаа түлж, залуу нь ус авчирч халаан, олон найз нөхөд,

хамаатан садныхаа ухяалын усыг халааж өгнө. Ийнхүү гурван өдөр үргэлжилсэн хурим өндөрлөнө. Харин орчин үед энэ бүхнийг ширхэгчлэн дагахаа больсон хэмээн өгүүллээ.

Өдгөө цагийн дэлхий дээр монгол соёлын орших хүрээ нь улс орны хил хязгаартай давхцахгүй. Монгол угсаатны бүлгүүд оршин аж төрж, монгол соёлын аль нэг зан үйл, заншил уламжлалыг хадгалсаар байгаа газар болгонд монгол соёл оршин байна гэсэн үг. Ер нь монгол соёлын эртний аль нэгэн хоцрол дэлхийн олон монгол угсаатны хаа нэгтээ заавал хадгалагдан үлдсэн байдаг нь сонирхолтой. Энэ нь Юннаны монголчуудын дунд Чингис хаан, Мөнх хаан, Хубилай хааны тайлга тахилга өнөө хүртэл уламжлагдан оршиж байгаагаар батлагдаж байна. Түүнээс гадна аливаа хэл соёл бусад хэл соёлд хэрхэн хайлж нэгддэгийн жишээг ч бас эндээс судалж болох юм гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

1. Du Iui Ting, Čen Liui Ban. Yünnan-u mongyol ündüsüten-ü tobči teüke. Öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a, 1980, Kökeqotan-a, 160-162
2. Генри Г. Шварц. Историческое происхождение юннанских монголов.
3. Yun nan tong hai xing meng: Meng gu zu ha zhuo yu.

SUMMARY

The cultural sphere of Mongolia is borderless; Mongolian culture will always exist anywhere a Mongol nation can sustain its culture and tradition. It is interesting to note that ancient Mongolian culture must have survived somewhere among the Mongol nations in the world. This is proven by the fact that Yunnan Mongols still worship Chinggis khaan, Munkh khaan and Hubilai khan through ritual practices.

Хавсралт/зохиогчийн авсан гэрэл зургууд/



Чингис хааны хөрөг баримал



Хубилай хааны хөрөг баримал



Мөнх хааны хөрөг баримал



Гурван богдын сүм



Хошууны засгийн ордон



Монгол, хятадаар бичсэн хаяг



Хошууны төвд буй монгол гуанз



Юннаны монголчуудын хоол



Усан тамхи нэрж байгаа нь



Юннаны монголчууд



Хошуу дарга түүний туслагчид



Тэд өмнөд орны хүнстэй болжээ



Монгол хувцас



Үндэсний хувцастай монгол бүсгүй



Зочид гийчдийг дуутай угтдаг